



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/АЧБ

Булган сум

**Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн  
тооллого явуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд мал тооллогын ажлыг 2025 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2.Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Аймаг, орон нутгийн эдийн засгийн голлох салбар болох мал тооллогын бэлтгэл ажлыг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, мал тооллогод бүрэн хамруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг мал тооллогын ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

4.Мал тооллогыг зохион байгуулахад шаардагдах зардал 10,306,000 төгрөг (арван сая гурван зуун зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

5.Мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлт, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтэс (М.Мөнхбат)-т үүрэг болгосугай.


6.Мал тооллогын урьдчилсан дүнг 2025 оны 12 дугаар сарын 23-нд, нэгдсэн дүнг 2026 оны 01 дүгээр сарын 10-ныг дотор танилцуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны  
12 дугаар сарын 01-ны/ний өдрийн  
А/ЗХС дугаар захирамжийн хавсралт



2025 оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын ажлын  
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
- Ажлын хэсгийн  
орлогч дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
- Гишүүд: Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын  
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)
- Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
дарга)
- Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
- Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга,  
хурандаа)
- Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд  
хурандаа)
- Нарийн бичгийн дарга: Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй  
хариуцсан мэргэжилтэн)